



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 0/116

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XIII хуралдааныг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1.Аймгийн хэмжээнд газрын харилцааны талаар 2022 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийн биелэлт, 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай

1.2.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн тухай

1.3.Үнэлэлт, дүгнэлт өгөх тухай (Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны биелэлтийн явц байдал)

1.4.Аймгийн 2022 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2023 оны төсөв батлах тухай

1.5.Дүгнэлт өгөх тухай (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын 2022 оны тайлан)

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XIII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

C:\My documents\Zahiramj

078140216

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн
А/11/6 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ XIII ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XIII хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

XI/10-ны дотор

Ажлын алба

2.Аймгийн хэмжээнд газрын харилцааны талаар 2022 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийн биелэлт, 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/25, XI/28, XII/01-ний дотор

Аймгийн ГХБХБГ-ын дарга Д.Цолмон

3.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн тухай шийдвэрийн төсөл боловсруулж, холбогдох тооцоо судалгаа, илтгэлийн хамт Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/25, XI/28, XII/01-ний дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

4.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны биелэлтийн явц байдлын тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/25, XI/28, XII/01-ний дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

5.Аймгийн 2022 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2023 оны төсөв батлах тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/25, XI/28, XII/01-ний дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

5.Аймгийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж Ажлын албанд ирүүлэх;

XI/25, XI/28, XII/01-ний дотор

Орхон аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх
аудитор Ц.Нармандах

6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын 2022 оны тайлан илтгэл, танилцуулга, шийдвэрийн төсөл боловсруулж Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/25, XI/28, XII/01-ний дотор

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

7.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

XI/30-ны дотор

Холбогдох Хороод

8.Төлөөлөгчид тойрогтоо ажиллах, сонгогчидтой уулзах, хуралдаанаас гарах шийдвэрийн төсөлд тусгуулах санал асуудлыг нэгтгэж Ажлын албанд ирүүлэх;

XI/30-ны дотор

Төлөөлөгчид

9.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XIII хуралдааны бэлтгэл хангасан дүнг Хурлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, илтгэл илтгэгчийг батлах;

XI/28-ны дотор

Хурлын дарга Д.Мөнхбат

10.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

XII/01-ний дотор

Ажлын албаны дарга Д.Эрдэнэцэцэг

АЖЛЫН АЛБА